

**ТӨВ АЙМГИЙН ЦАГДААГИЙН ГАЗРЫН НЭРЭМЖИТ**  
**“POLICE CUP- 2019” EQUIPPED POWERLIFTING**  
**АЙМГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2019-05-22

Зуунмод

**Нэг: Зорилго:**

Пауэрлифтингийн спортоор хичээллэх хүрээг нэмэгдүүлэх, шинэ залуу тамирчдыг төрүүлэн гаргах, тамирчдын бэлтгэлжилт, ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцуулахад оршино.

**Хоёр: Тэмцээний зохион байгуулалт, явуулах хугацаа:**

Тэмцээн 2019 оны 06-р сарын 14-15-нд Төв Аймгийн БТС-ын Газар, Хүч Тамирын Нэгдсэн Холбоо хамтран зохион байгуулна. Тэмцээнийг Төв Аймгийн Хүч Тамирын Нэгдсэн Холбооноос томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн зохион байгуулж явуулна.

**Гурав: Тэмцээний техникийн зөвлөгөөн, жин үзэх:**

Тэмцээн 2019 оны 06-р сарын 14-ны өдрийн 09:00 цагаас эхлэх ба 2019 оны 06-р сарын 14-ны өдрийн 08:00 цагаас техникийн зөвлөгөөн явагдаж тамирчдын жин үзнэ. /бичиг баримт, иргэний үнэмлэхтэй ирнэ/. Тэмцээн Equipped төрлөөр тусгай зориулалтын хувцас хэрэглэлтэйгээр явагдна. /Тэмцээний эрхийн мандат 20.000 төгрөг, Өсвөр 10.000 төгрөг /насанд хүрэгчид , залуучууд / Төв аймгийн харьяалалтай тамирчид оролцно

**Дөрөв: Тэмцээний жин, ангилал:**

- Өсвөр: 18 нас хүртэл 59 кг,-66 кг, 74 кг, +74 кг
- Охид –57кг, 63 кг, +63кг, Эмэгтэй,-63,+63, Мастер
- Залуучууд: 18-23 нас 66кг -74кг +74кг
- Насандхүрэгчид:, 74кг ,83кг, 93кг,105кг.+105

**Тав: Шагнал урамшуулал:**

Тэмцээний төрөл тус бүрт: 1, 2, 3-р байр эзэлсэн тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөн нийлбэр дүнгээр 1, 2, 3-р байр эзэлсэн тамирчдад алт, мөнгө, хүрэл медаль, үнэмлэхүй цом, өргөмжлөлөөр шагнаж урамшуулна.

**ТӨВ АЙМГИЙН ХҮЧ ТАМИРЫН  
НЭГДСЭН ХОЛБОО**

**“АТАРЧИН-2018” СПОРТЫН НААДМЫН ЗААВАР**

2018-12-05

Зуунмод

**Нэг. Зорилго:**

Монгол улсын хууль тогтоомжийг сурталчилах ажлын хүрээнд иргэдийг биеийн тамир спортоор хичээллэх хүрээг нэмэгдүүлэх, спортын наадмыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, харилцан туршлага солилцуулахад оршино.

**Хоёр. Тэмцээний зохион байгуулалт, явуулах хугацаа:**

“Атарчин-2018” спортын наадмыг 2018 оны 12-р сарын 15-16- нд Зуунмод суманд Аймгийн БТС-ын Газар, Зуунмод сумын ЗДТГазар, Спортын холбоод хамтран зохион байгуулна. Тэмцээнийг Аймгийн БТС-ын газраас томилогдсон шүүгчдийн бүрэлдэхүүн зохион байгуулж явуулна.

**Гурав. Спортын төрөл, багийн бүрэлдэхүүн:**

1. Волейбол эр 7, эм 7 /нэг багт ЕБС-ийн 2 сурагч орохыг зөвшөөрнө
2. Ширээний теннис эр 1, эм 1
3. Шатар эр 1, эм 1 /СДМ цолтой өсвөрийн тамирчид оролцож болно/
4. Үндэсний бөх /сумаас 2 залуу бөх /
5. Шагайн харваа эр 7 хүнтэй баг оролцоно

Тэмцээнд зөвхөн Төв аймгийн харъяат насанд хүрэгчид /18-аас дээш насны/ оролцоно.

**Дөрөв. Бүрдүүлэх бичиг баримт:**

1. Иргэний үнэмлэх
2. 3 х 4 хэмжээтэй 1 % цээж зураг
3. Багийн мэдүүлэг
4. Эрхийн төлбөр 3000 төгрөг

**Тав. Шагнал урамшил:**

Тэмцээний төрөл тус бүрд 1, 2, 3-р байр эзэлсэн баг тамирчдыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар, байгууллагын нэгдсэн дүнгээр 1-р байр эзэлсэн сумыг цом, өргөмжлөл, спортын хэрэглэл материалаар, 2, 3-р байр эзэлсэн сумдыг өргөмжлөл, спортын хэрэглэл материалаар шагнана.

**Зургаа. Төсөв зардал:**

Тэмцээнд оролцох тамирчдын байр, хоол, унааны зардлыг тухайн сум, албан байгууллага хариуцана.

**Долоо. Анхаарах зүйл:**

1. 2018 оны 12-р сарын 14-ны 14.00-20.00 цагт мандат олгож, 20.00 цагаас техникийн зөвлөгөөнийг Аймгийн БТС-ын Газрын хурлын танхимд хийнэ.
2. Тэмцээнд оролцох баг тамирчид тоглолтын дүрмийн шаардлага хангасан жигд хувцас формтой байна.
3. Волейболын тэмцээнд оролцох ЕБС-ийн сурагчид заавал иргэний үнэмлэхтэй байна.
4. Мандатын материал дутуу, хоцорч ирсэн тамирчид тэмцээнд оролцох боломжгүй болохыг анхааруулж байна.
5. Тэмцээнд оролцох урьдчилсан мэдүүлэгээ 12-р сарын 14-ны дотор 99308228, 99794599 утсаар мэдэгдэнэ үү.
6. Багийн дүнг бүх төрөлд оролцсон тохиолдолд гаргана.
7. Тэмцээнтэй холбоотой асуудлыг лавлах утас 99308228, 99794599,

**Тэмцээн зохион байгуулах комисс**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖИЙГ СУРТАЛЧИЛАХ АЖЛЫН ХҮРЭЭНД  
ЗОХИОН БАЙГУУЛАХ УИХ-ЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН БАТЛАН  
ХАМГААЛАХЫН САЙД Н.ЭНХБОЛДЫН НЭРЭМЖИТ “АТАРЧИН-2018” СПОРТЫН  
НААДМЫН ТӨСӨВ ЗАРДАЛ**

2018-12-05

Зуунмод

№	Юунд зарцуулах	1-р байр	2-р байр	3-р байр	Бүгд дүн
1	Волейбол /эр 7, эм 7 /	14 x 25.000 = 350.000	14 x 20.000 = 280.000	14 x 15.000 = 210.000	840.000
2	Ширээний теннис /эр1, эм 1/	2 x 25.000 = 50.000	2 x 20.000 = 40.000	2 x 15.000 = 30.000	120.000
3	Шатар /эр1, эм 1/	2 x 25.000 = 50.000	2 x 20.000 = 40.000	2 x 15.000 = 30.000	120.000
4	Шагайн харваа /баг 7 хүнтэй/	7 x 25.000 = 175.000	7 x 20.000 = 140.000	7 x 15.000 = 105.000	420.000
5	Үндэсний бөх	100.000	80.000	2 x 50.000 = 100.00	280.000
6	Өргөмжлөл	Жаазтай 19 ш x 10.000 = 190.000 Жижиг 63 ш x 2500 = 157.500			347.500
7	Медаль	82 ш x 8.000			656.000
8	Анос				95.000
9	Багийн шагнал	250.000	200.000	150.000	600.000
10	Шүүгчдийн зардал	28 хүн x 2 хоног x 25.000			1.400.000
	Нийлбэр дүн		4.878.500 төгрөг		

Арга зүйч

Төсөв хийсэн

Л.Хишигдэлгэр

**АРДЫН БОЛОВСРОЛЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН,  
БИЕЙН ТАМИРЫН ТЭРГҮҮНИЙ АЖИЛТАН, ВОЛЕЙБОЛЫН СПОРТЫН МАСТЕР  
С.АЛТАНХУЯГ АГСАНЫ НЭРЭМЖИТ ӨСВӨРИЙН ВОЛЕЙБОЛЫН АЙМГИЙН АВАРГА  
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ**

2018.11.12

Зуунмод

**ТЭМЦЭЭНИЙ ЗОРИЛГО:**

Волейболын спортыг сурталчилах, өсвөр насны тамирчдын ур чадварыг дээшлүүлэх, волейболын спортод дур сонирхолтой болгох, харилцан туршлага солилцох, чадварлаг тамирчид төрүүлэн гаргахад оршино.

**ТЭМЦЭЭНИЙХУГАЦАА:**

Тэмцээн 2018 оны 11-р сарын 24-25-ны өдрүүдэд Төв аймгийн Батсүмбэр сумын сургуулийн спорт зааланд болно.

**ТЭМЦЭЭНИЙ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ:**

- Тэмцээнийг аймгийн БТСГазар, АБТА, БГТА, Волейболын спортын мастер С.Алтанхуяг агсаны гэр бүл, үр хүүхдүүд, үе үеийн шавь нар хамтран зохион байгуулна.
- Тэмцээнд оролцох мандатыг 2018.11.23-ны 16<sup>00</sup>-20<sup>00</sup> цагийн хооронд сургууль дээр олгоно.
- Тэмцээний техникийн зөвлөгөөн 2018 оны 11 сарын 23-ны 20<sup>00</sup> цагт багш нарын өрөөнд хийнэ.
- Тэмцээний нээлтийн үйл ажиллагаа 2018.11.24-ны 12<sup>00</sup>цагт “*Спортын заал*”-нд эхэлнэ.

**БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, НАС, ХҮНИЙ ТОО:**

- Тэмцээнд сум, сургуулиудаас 17 хүртлэх насны охид 8, хөвгүүд 8 хүний бүрэлдэхүүнтэй баг тамирчид оролцоно.

**ТАМИРЧДЫН БҮРДҮҮЛЖ ИРЭХ БИЧИГ БАРИМТ:**

- Төрсөний гэрчилгээ /Эх хувиараа/
- Эрүүл мэндийн дэвтэр /Эх хувиараа/
- Сурагчийн хувийн хэрэг /Эх хувиараа/
- 1% цээж зураг /Сүүлийн 3 сард авахуулсан зураг байх/
- Эрхийн төлбөр / Тамирчин тус бүр 2500 төгрөг/
- Мэдүүлэг албан ёсны баталгаатай байх

## ШАГНАЛ УРАМШУУЛАЛ:

Эрэгтэй, эмэгтэй тамирчид тус бүр /насны ангилал тус бүрээр/

- 1-р байр – алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
- 2-р байр – мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
- 3-р байр – хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал
- Шилдэг тоглогч – 2 шалгаруулна

## ТАЙЛБАР:

1. Мандатыг материалгүй, бичиг баримтны зөрчилтэй тамирчдад олгохгүй, тэмцээнд оруулахгүй болно.
2. Тэмцээнд оролцох багууд дүрмийн шаардлага хангасан тоглолтын жигд хувцастай байна.
3. Тэмцээнд оролцох тамирчдын аюулгүй байдлыг хангасан унаа машинаар ирэх
4. Тамирчдын байр, хоол, унааны зардлыг тухайн сум, албан байгууллага хариуцана.
5. Мэдүүлэгийг дараах загвараар хийх

№	Зураг	Овог, нэр	Регистрийн дугаар	Нас	Хүйс	Номер	Тоглогчийн үүрэг	Эрүүл мэндийн байдал
1								

**Холбоо барих утас: 99308228, 90606090**

ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ ДАРГА Ч.САРАНГЭРЭЛ

ТӨВ АЙМГИЙН  
БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН НЭРЭМЖИТ ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН ИХ НААДМЫН ЗААВАР

### Нэг. Зорилго:

Аймаг, сум, багийн иргэдийн дунд бүх нийтийн биеийн тамир, спортын арга хэмжээ, тэмцээн наадмыг нэгдмэл удирдлага зохион байгуулалттайгаар иргэдийн сонирхол, хэрэгцээнд тулгуурлаж явуулах, тэдгээрийг биеийн тамир, спортоор хичээллэх, идэвхитэй эрүүл амьдрах боломжийг бүрдүүлэх, багийн спортын төрлүүдийг хөгжүүлэх, сумдын биеийн тамир, спортын үйл ажиллагааг дэмжихэд оршино.

### Хоёр. Зохион байгуулагдах хугацаа, үе шат:

Наадам 2 үе шаттайгаар зохион байгуулагдана.

**Нэгдүгээр үе:** Сум, баг, аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 09 дүгээр сарын 21-наас 30-ны хооронд

**Хоёрдугаар үе:** /шигшээ тэмцээн/

Аймгийн аварга шалгаруулах тэмцээн 2018 оны 10 дугаар сарын 05-наас 07-ны хооронд

### Гурав. Зохион байгуулалт, тайлан:

Анхан шатны тэмцээнийг сумд багуудын дунд зохион байгуулж, шалгарсан баг, тамирчдыг аймгийн аварга шалгаруулах тэмцээнд оролцуулна. Анхан шатны тэмцээний тайлан мэдээ, зургийн хамт 2018 оны 10 дугаар сарын 04-ны дотор Биеийн Тамир, Спортын Газарт [Enkhtsetseg\\_1122@yahoo.com](mailto:Enkhtsetseg_1122@yahoo.com) буюу ДУС-аар ирүүлнэ.

Шигшээ тэмцээний зохион байгуулалтыг Аймгийн Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын газар хариуцан зохион явуулна.

### Дөрөв. Оролцогчдод тавигдах шаардлага

Багийн бүрэлдэхүүнд тухайн хороо болон сумын иргэн байх ба зөвхөн цахим үнэмлэх, болон шилжилт хөдөлгөөний нарийн хуудас / кодтой / үндэслэн наадамд оролцуулна.

- 18 ба түүнээс дээш настай тухайн сумын харьяат иргэн байх
- **Аймгийн наадамд оролцож байгаа тамирчин спортын зөвхөн нэг төрөлд оролцоно.** Тамирчид тэмцээний явцад согтууруулах ундаа хэрэглэсэн, зүй бус үйлдэл гаргасан, тэмцээнд давхардаж орсон тохиолдолд багийг тэмцээнээс шууд хасна.
- Баг тамирчид тухайн спортын төрлийн дүрэмд тохирсон хувцастай байна.
- Наадамд спортын дэд мастераас дээш цолтой тамирчин оролцвол 45-с дээш настай байна.
- Тамирчдын эрүүл мэнд, бусад холбогдох асуудлыг тухайн байгууллага, орон нутаг хариуцна.

### Тав. Наадмын тэмцээний төрөл

Тэмцээн Сагсан бөмбөг, Волейбол, Хөлбөмбөг шууд шигшээ наадамд оролцно Олс таталт, Явган аялалын төрлүүдийг сум, баг иргэдийн дунд өөрсдөө зохион байгуулан тайлан мэдээг [Enkhtsetseg\\_1122@yahoo.com](mailto:Enkhtsetseg_1122@yahoo.com) хаягаар буюу ДУС-аар тайлангийн хамт ирүүлнэ

№	Спортын төрөл	Багийн бүрэлдэхүүн	Нас
1	Сагсан бөмбөг	Эрэгтэй 8, эмэгтэй 8, тус бүр 1 дасгалжуулагч	31-с дээш
2	Волейбол	Эрэгтэй 8, эмэгтэй 8 тус бүр 1 дасгалжуулагч	31-с дээш
3	Хөлбөмбөг	Эрэгтэй 12, тамирчин, 1 дасгалжуулагч	18-с дээш

**1. Сагсан бөмбөг** 2018 оны 10 дугаар сарын 06-07-нд Аймгийн БТС-ын газрын спортын ордонд

Эрэгтэй, эмэгтэй баг тус бүр нь 8 хүний бүрэлдэхүүнтэй тус бүр 1 дасгалжуулагчтай байна. Тэмцээний тоглолтын цаг эрэгтэй 8 минут, эмэгтэй 6 минутаар 2 үе тоглож дүнг гаргана. Эрэгтэй, эмэгтэй 1 шилдэг тоглогч шалгаруулна

**2. Волейбол** 2018 оны 10 дугаар сарын 06-07-нд Хүүхэд залуучуудын ордонд спорт зааланд

Эрэгтэй, эмэгтэй баг тус бүр нь 8 хүний бүрэлдэхүүнтэй, тус бүр 1 дасгалжуулагчтай байна. Тоглолт 15 оноогоор явагдана. Эрэгтэй эмэгтэй 1 шилдэг тоглогч шалгаруулна

**3. Хөлбөмбөг** 2018 оны 10 дугаар сарын 06-07-нд БТСГ-ын хөлбөмбөгийн талбайд **18**-аас дээш насны 7 хүнтэй, баг тус бүр 3 сэлгээ тамирчин, 1 дасгалжуулагчтай нийт 11 хүний бүрэлдэхүүнтэй, тоглолтын хугацаа 12x12 минут байна. Тоглолт хасагдах системээр явагдана. Шилдэг тоглогч шалгаруулна.

### **Зургаа. Мэдүүлэг хүлээн авах журам, бүрдүүлэх материал**

Тамирчдын бичиг баримтанд иргэний үнэмлэхийг шалгуур болгоно. Мэдүүлгийн хамт иргэний үнэмлэхний хуулбар хавсаргана. Биеийн тамир, Спортын Газраас гаргасан загварын дагуу мэдүүлгийг авна. Тамирчид шат шатны тэмцээнд хамрагдсан байна.

#### **МЭДҮҮЛЭГТ:**

- Овог нэр бүтэн бичигдсэн байх
- Регистрийн дугаар
- Цээж зураг / сүүлийн 1 жил дотор авахуулсан танигдахуйц байх/
- Стандартын дагуу бичих / гар бичвэр хүлээж авахгүй /
- Даргын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажсан байна.
- Эрүүл мэндийн үзлэг хийсэн эмчийн гарын үсэг, тамгатай байна.
- Эрхийн төлбөр 3000 төгрөг

/Мэдүүлгийг [Enkhtsetseg\\_1122@yahoo.com](mailto:Enkhtsetseg_1122@yahoo.com) 10-р сарын 03-ны дотор цахим хаягаар ирүүлнэ. Урьдчилсан мэдүүлэг өгөөгүй багийг тэмцээнд оролцуулахгүй.

#### **Долоо. Техникийн зөвлөгөөн**

Нэгдсэн техникийн зөвлөгөөн 2018 оны 10 дугаар сарын 03-ны 10.00 цагаас цахимаар зохион байгуулж, сугалааг сугална. Цахим хуралд багийн ахлагчид оролцоно.

#### **Найм. Шагнал урамшуулал:**

Тэмцээний төрөл тус бүрт 1, 2, 3 дугаар байр эзлүүлж медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Тэмцээний бүх төрлийн нийлбэр дүнгээр 1, 2, 3, дугаар байр эзэлсэн сумдыгцом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна

- 1-р байр 1,000,000₮, цом өргөмжлөл, спортын хэрэглэл материал
- 2-р байр 700,000 ₮, цом өргөмжлөл, спортын хэрэглэл материал
- 3-р байр 500,000₮, цом өргөмжлөл, спортын хэрэглэл материал

Орон нутагтаа иргэдийн наадмыг амжилттай зохион байгуулсан 15 сумыг спортын хэрэглэл материалаар шагнаж урамшуулна.

#### **Ес. Багийн нэгдсэн дүн:**

1. Орон нутагт иргэдийн спортын наадмыг зохион байгуулсан тайлан мэдээ, Аялал, орс таталтын тэмцээнүүдийг зохион байгуулсан дүн. /зураг CD/
2. Шигшээ тэмцээнд оролцсон дүн

3. Байгууллагын дүнг гаргахдаа бага онооны системээр дүгнэнэ. Тэмцээний төрөлд огт оролцоогүй бол 27 оноо өгнө.
4. Тэмцээнд оролцох тамирчдын байр, хоол, унааны зардлыг тухайн байгууллага хариуцана.

Аймгийн БТС-ын Газар

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН НЭРЭМЖИТ ТӨВ АЙМГИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН ИХ НААДМЫН ХӨТӨЛБӨР

2018-09-25

Зуунмод

- Сумд багуудын дунд иргэдийн спортын наадмын анхан шатны тэмцээнийг зохион байгуулах
  - 2018.09.21-2018.10.01 - Сумдын ЗДТГазар
- Анхан шатны тэмцээний тайланг БТС-ын газарт хүргүүлэх /заавар удирдамжийн дагуу/
  - 2018.10.01 – 2018.10.03 - Сумдын ЗДТГазар
- Аймгийн иргэдийн спортын наадамд оролцох баг тамирчдын мэдүүлэгийг өгөх. БТСГ-аас гаргасан загварын дагуу
  - 2018.10.01 – 2018.10.03 18<sup>00</sup> цаг хүртэл [Enkhtsetse\\_1122@yahoo.com](mailto:Enkhtsetse_1122@yahoo.com) хаягаар ба ДУС-аар өгөх
- Сумдын ЗДТГ-тай Аймгийн Иргэдийн спортын наадмыг зохион байгуулах хороо цахим хурал зохион байгуулах
  - 2018-10-03 ны өдрийн 10<sup>00</sup> цагт
  - Хуралд сумдын ЗДТГ-ын дарга
  - Тэмцээнд оролцогчдыг хариуцах багийн ахлагчид
  - Сумдын НБ-ын ажилтнууд болон БТ-ын багш нар оролцоно.
  - Тэмцээний мэдээлэл өгөх
  - Төрөл тус бүрийн сугалааг хийх

### 2018 оны 10-р сарын 06-нд Бямба гараг

- 8<sup>00</sup> – 11<sup>00</sup> цаг  
12<sup>00</sup> – 21<sup>00</sup> цаг Волейбол /эрэгтэй, эмэгтэй/ урьдчилсан тоглолт Хүүхэд залуучуудын ордон  
/спорт заал/  
8<sup>00</sup> – 11<sup>00</sup> цаг  
12<sup>00</sup> – 21<sup>00</sup> цаг Сагсан бөмбөг /эрэгтэй, эмэгтэй/ урьдчилсан тоглолт БТС-ын Газар  
/спортын ордон/  
8<sup>00</sup> – 11<sup>00</sup> цаг  
12<sup>00</sup> – 18<sup>00</sup> цаг Хөл бөмбөг /эрэгтэй/ Хөл бөмбөгийн талбайд  
11<sup>00</sup> – 11<sup>40</sup> –д Нээлтийн ажиллагаа Мөнх Алдарын талбайд

### 2018 оны 10-р сарын 07-нд Ням гараг

- 8<sup>00</sup> – 15<sup>00</sup> цаг Волейбол /эрэгтэй, эмэгтэй/ шигшээ тоглолт Хүүхэд залуучуудын ордон  
/спорт заал/  
8<sup>00</sup> – 15<sup>00</sup> цаг Сагсан бөмбөг /эрэгтэй, эмэгтэй/ шигшээ тоглолт /БТСГ спортын ордон /  
8<sup>00</sup> – 15<sup>00</sup> цаг Хөл бөмбөг шигшээ тоглолт /Хөл бөмбөгийн талбайд/  
15<sup>00</sup> – 16<sup>00</sup> Тэмцээний хаалтын ажиллагаа, шагнал гардуулах  
Аймгийн БТС-ын Газар



Мэдүүлэг авах эцсийн хугацаа 2018.10.03-нд  
Мэдүүлэг авах хаяг Enkhtsetseg\_1122@yahoo.com

**МЭДҮҮЛЭГИЙН ЗАГВАР**

БАТЛАВ. ....СУМЫН ЗАСАГ ДАРГА \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
/гарын үсэг/ /нэр/

АЙМГИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН НААДАМД \_\_\_\_\_ СУМААС  
САГСАН БӨМБӨГИЙН ТӨРӨЛД ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧДЫН МЭДҮҮЛЭГ

№	Зураг	Овог	Нэр	Хүйс	Регистрийн дугаар	Спортын зэрэг	Эрүүл мэнд
1							
16							

Багийн дасгалжуулагч \_\_\_\_\_ / ..... /  
/гарын үсэг/ /овог нэр/

ТАМГА

Үзлэг хийсэн эмч \_\_\_\_\_ / ..... /  
/гарын үсэг/ /овог нэр/

БАТЛАВ. ....СУМЫН ЗАСАГ ДАРГА \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
/гарын үсэг/ /нэр/

АЙМГИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН НААДАМД \_\_\_\_\_ СУМААС  
ВОЛЕЙБОЛЫН ТӨРӨЛД ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧДЫН МЭДҮҮЛЭГ

№	Зураг	Овог	Нэр	Хүйс	Регистрийн дугаар	Спортын зэрэг	Эрүүл мэнд
1							
16							

Багийн дасгалжуулагч \_\_\_\_\_ / ..... /  
/гарын үсэг/ /овог нэр/

ТАМГА

Үзлэг хийсэн эмч \_\_\_\_\_ / ..... /  
/гарын үсэг/ /овог нэр/

БАТЛАВ. ....СУМЫН ЗАСАГ ДАРГА \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
/гарын үсэг/ /нэр/

АЙМГИЙН ИРГЭДИЙН СПОРТЫН НААДАМД \_\_\_\_\_ СУМААС  
ХӨЛ БӨМБӨГИЙН ТӨРӨЛД ОРОЛЦОХ БАГ ТАМИРЧДЫН МЭДҮҮЛЭГ

№	Зураг	Овог	Нэр	Хүйс	Регистрийн дугаар	Спортын зэрэг	Эрүүл мэнд
1							
16							

Багийн дасгалжуулагч \_\_\_\_\_ / ..... /  
/гарын үсэг/ /овог нэр/

ТАМГА

Үзлэг хийсэн эмч \_\_\_\_\_ / ..... /  
/гарын үсэг/ /овог нэр/

- Мэдүүлгийг тус бүрд нь хийж ирүүлэх

- Төрөл тус бүрд оролцох тамирчдын цахим үнэмлэхний хуулбарыг мэдүүлэгтэй хамт ирүүлнэ.

**МУЫН ЕРӨНХИЙ САЙДЫН НЭРЭМЖИТ ИРГЭДИЙН СПОРТЫН  
НААДМЫН СУМДАД ЗОХИОН БАЙГУУЛАХ, МЭДЭЭ  
ТАЙЛАНГ НЭГТГЭХ БАГШ ДАСГАЛЖУУЛАГЧДЫН ХУВААРЬ**

№	Сумдын нэр	Хариуцах эзэн
1	Аргалант	Л.Энхбаяр
	Алтанбулаг	
	Архуст	
	Баянжаргалан	
2	Баяндэлгэр	Ц.Батзаяа
	Баянцагаан	
	Баянхангай	
	Баян-Өнжүүл	
3	Баянцогт	Л.Хишигдэлгэр
	Баянчандмань	
	Баян	
	Батсүмбэр	
	Борнуур	
	Бүрэн	
4	Дэлгэрхаан	Д.Энхцэцэг
	Жаргалант	
	Заамар	
	Лүн	
	Угтаал	
	Цээл	
5	Мөнгөнморьт	Д.Алтанхуяг
	Өндөрширээт	
	Сэргэлэн	
	Сүмбэр	
	Эрдэнэ	
	Эрдэнэсант	
	Зуунмод	

Д.Мөнх-Эрдэнэ, Э.Сайнзаяа нар мэдээ тайланг нэгтгэх

БАТЛАВ.  
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН  
ГАЗРЫН ДАРГА  
Г.ЛХАГВАСҮРЭН

БАТЛАВ.  
“ТӨВ АЙМГИЙН ЗАЛУУС ТББ”  
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ  
Г.ТЭМҮҮЖИН

• TUV+2030 •

/Оюутан, залуусын эко явган аялал/

**Зорилго:** Төв аймгийн оюутан, залуусын эрүүл мэнд, дасгал хөдөлгөөнөөр хичээллэх идэвхийг нэмэгдүүлэх, Төв аймгийн байгалийн болон түүхийн дурсгалт газруудтай танилцах, хувь хүний хөгжил, нийгмийн идэвх оролцоо, сайн дурын үйл ажиллагааны талаар шинэ мэдлэг, мэдээлэлтэй болох, оюутан, залуус чөлөөт цагаа зөв боловсон, үр дүнтэй өнгөрүүлэх, шинэ найз нөхөдтэй болох, шинэ хамт олонд нэгдэх,

**Зохион байгуулагч:** Төв аймгийн БТСГ, “Төв аймгийн залуус” ТББ

**Хэзээ:** 2018.10.06, 09:00 цагт

**Хаана:**

1. Төв аймгаас оролцогсад /Зуунмод сумын “Мөнх-Алдар”-ын талбайд цуглана/
2. Улаанбаатар хотоос оролцогсад /Хан-Уул дүүрэг “Чингисийн өргөө” амралт жуучны баазын урд талбайд цуглана/

**Хамрах хүрээ:** TUV+2030 фестивалд оролцсон болон оролцож чадаагүй Төв аймгийн оюутан, залуус,

**Бэлтгэл:**

1. Гадаа цаг агаарт, уул хаданд явахад тохиромжтой хувцаслах,
2. Бүлэг бүлгээрээ эсвэл дангаараа өөрсдийн хоол, ундыг бэлдэх,
3. Ажлын бээлий, хогийн уут, шуудай авч ирэх,

**Анхаарах зүйл:**

1. Цаг барих,
2. Арга хэмжээнд бүрэн оролцох,
3. Бүлгийн гишүүд өнгө өнгийн хувцасаар жигдэрэх, шинээр оролцогчид цагаан өнгөөр жигдрэх,
4. Зохион байгуулагчдын шаардлагыг биелүүлэх,
5. Согтууруулах ундааны зүйл хэрэглэхийг хориглоно,

**Бүртгэл:**

1. TUV+2030 фестивалд оролцсон залуус бүлгийн чиглүүлэгч нартаа хандаж, бүртгүүлнэ.
2. Арга хэмжээнд оролцох хүсэлтэй чөлөөт оюутан, залуус зохион байгуулагч нарт [Төв аймгийн залуус ТББ / Tuv aimgiin zaluus TBB](#) хуудас болон утсаар холбогдож бүртгүүлнэ. Үүнд:

**Оюутан:**

Овог:  
Нэр:  
Аль сумын харъяарт:  
Сургууль:  
Сурч буй мэргэжил:

**Залуус:**

Овог:  
Нэр:  
Аль сумын харъяат:  
Хөдөлмөр эрхлэлт:  
Утасны дугаар:

Утасны дугаар:  
Яаралтай үед холбогдох утас:  
Нүүр ном:

Яаралтай үед холбогдох утас:  
Нүүр ном:

**Холбоос:** <https://www.facebook.com/Tuvaimgiinzaluus/>

**Холбоо барих:**

1. Г.Тэмүүжин /Төв аймгийн залуус ТББ-ын гүйцэтгэх захирал/ - 99307169,
2. Б.Довдонцэрэн /Төв аймгийн залуус ТББ-ын У/З-ийн дарга/ - 95100667,

### **ХӨТӨЛБӨР**

08:00-08:30 Бүртгэл /Зохион байгуулагч, бүлгийн чиглүүлэгч нар/,  
08:30-09:00 Нээлтийн үйл ажиллагаа /Тууз гардуулах/,  
09:00-10:20 Нэгдүгээр амралт хүртэлх алхалт,  
10:20-11:00 Амралт (Өглөөний цай)  
11:00-12:00 Хоёрдугаар амралт хүртэлх алхалт,  
12:00-13:00 Амралт (Бүлгийн мэндчилгээ)  
13:00-14:00 Гуравдугаар амралт хүртэлх алхалт,  
14:00-14:40 Амралт (Өдрийн хоол)  
14:40-15:30 “Цэцээ гүн”-ий ноён оргилд гарах,  
15:30-16:30 Амралт (Лекц) ( Олс таталт, Буухиа тэмцээн зохион байгуулах)  
16:30-17:30 Уулнаас буух(Хог цэвэрлэх)  
17:30-18:00 Түр амралт /Цайны завсарлага/  
18:00-19:00 Уулнаас буух (Цугласан газраа ирэх)  
19:00-19:30 Гэр гэртээ харих

Төв аймгийн Биеийн тамир, спортын газар,  
Төв аймгийн залуус ТББ  
--oOo--

БАТЛАВ.  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

“MASTER-CUP”-2018 КРОСС УРАЛДААНЫ АЙМГИЙН АВАРГА  
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР.

2018-08-15

Зуунмод

### **Нэг. Зорилго:**

Хөнгөн атлетикийн спортыг хөгжүүлэх гүйлтийн төрлөөр хичээллэх хүүхэд залуучуудыг өргөнөөр хамруулах, хүүхэд гэр бүлийн эрүүл мэндийг дэмжих, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, өсвөрийн шигшээ багийн тамирчдыг сонгон шалгаруулах, спортын амжилтыг нь ахиулахад оршино.

### **Хоёр. Тэмцээний хугацаа, зохион байгуулах газар**

Тэмцээн 2018 оын 09-р сарын 15-ны өдөр Төв аймаг Зуунмод сумын Мөнх Алдрын талбайд болно.Тэмцээнийг Аймгийн БТС-ын Газар зохион байгуулан явуулна.

### **Гурав. Тэмцээний төрөл зай, оролцох хүний тоо:**

Тэмцээнийг 5-н насны ангилалаар зохион явуулна.

1. 8-9 насанд Охид 1, Хөвгүүд 1- 800 м
2. 10 -11 насанд Охид 1, Хөвгүүд 1- 1200 м
3. 12-13 насанд Охид 2 м, Хөвгүүд 2- 1500 м
4. 14-15 насанд Охид 1 м, Хөвгүүд 1- 3000 м
5. 16-17 насанд Охид 1 м, Хөвгүүд 1- 4000 м

### **Дөрөв. Тэмцээний шагнал урамшил:**

Тэмцээний зай тус бүрт 1-3-р байр эзэлсэн тамирчдад алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулна.

Багийн нэгдсэн дүнгээр 1-р байр эзэлсэн багийг цом, өргөмжлөл, мөнгөн шагнал 2-5-р байр эзэлсэн багийг өргөмжлөл мөнгөн шагналаар шагнаана.

Багийн дүнг гаргахдаа 12 тамирчны үзүүлсэн амжилтын нийлбэрээр гаргана.

Жич: 1. Тэмцээн 2018 оны 09-р сарын 15-ны 11.00 цагт эхэлнэ.

2. Тэмцээнд баг тамирчдаа оролцуулж буй байгууллага, аж ахуйн нэгжүүд байр, хоол, унааны зардлаа өөрсдөө хариуцана.

Тэмцээнд оролцох тамирчид холбогдох бичиг баримтаа зааврын дагуу бүрдүүлж ирнэ.

1. Хувийн хэрэг
2. Иргэний үнэмлэх
3. Төрсний гэрчилгээ
4. ЭМД –ын дэвтэр
5. 2 % цээж зураг
6. Эрхийн төлбөр 2500 төгрөг
7. Тамирчид тусгай номер олгоно

Жич: Урьдчилсан мэдүүлгийг 2018 оны 09-р сарын 10-ны дотор [Enkhtsetseg\\_1122@yahoo.com](mailto:Enkhtsetseg_1122@yahoo.com) хаягаар болон дотоод удтодлагын системээр ирүүлнэ.

Холбоо барих утас: 99308228

Аймгийн БТС-ын Газар

БАТЛАВ.

АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН

ДАРГА

Га.ЛХАГВАСҮРЭН

“GOOD NEIGHBORS MONGOLIA” ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГЫН  
НЭРЭМЖИТ КРОСС УРАЛДААНЫ УЛСЫН АВАРГА  
ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР.

2018-08-15

Зуунмод

### **Нэг. Зорилго:**

Хөнгөн атлетикийн спортыг хөгжүүлэх гүйлтийн төрлөөр хичээллэх хүүхэд залуучуудыг өргөнөөр хамруулах, хүүхэд гэр бүлийн эрүүл мэндийг дэмжих, тэдний бие бялдрыг чийрэгжүүлэх, өсвөрийн шигшээ багийн тамирчдыг сонгон шалгаруулах, спортын амжилтыг нь ахиулахад оршино.

**Хоёр. Тэмцээний хугацаа, зохион байгуулах газар**

Тэмцээн 2018 оын 09-р сарын 15-ны өдөр Төв аймаг Зуунмод сумын Мөнх Алдрын талбайд болно.Тэмцээнийг Аймгийн БТС-ын Газар, “Good Neighbors Mongolia” олон улсын байгууллага, Түмэн ачлал ТББ, МХАХолбоо хамтран зохион байгуулан явуулна.

### **Гүрав. Тэмцээний төрөл зай, оролцох хүний тоо:**

Тэмцээнийг 5-н насны ангилалаар зэрэгтэй тамирчид, сонирхогчдын гэсэн 2 хэлбэрээр зохион явуулна.

1. 8-9 насанд Охид 1, Хөвгүүд 1- 800 м
2. 10 -11 насанд Охид 1, Хөвгүүд 1- 1200 м
3. 12-13насанд Охид 2 м, Хөвгүүд 2- 1500 м
4. 14-15насанд Охид 1 м, Хөвгүүд 1- 3000 м
5. 16-17насанд Охид 1 м, Хөвгүүд 1- 4000 м

### **Дөрөв. Тэмцээний шагнал урамшил:**

Тэмцээний зай тус бүрт 1-3-р байр эзэлсэн тамирчдад алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнаж урамшуулна.

Багийн нэгдсэн дүнгээр 1-р байр эзэлсэн багийг цом, өргөмжлөл, мөнгөн шагнал 2-5-р байр эзэлсэн багийг өргөмжлөл мөнгөн шагналаар шагнана.

Багийн дүнг гаргахдаа 12 тамирчны үзүүлсэн амжилтын нийлбэрээр гаргана.

Жич: 1. Тэмцээн 2018 оны 09-р сарын 15-ны 11.00 цагт эхэлнэ.

2 Аймгуудын БТС-ын Газар, байгууллага, аж ахуйн нэгжүүд байр, унааны зардлаа өөрсдөө хариуцана.

Тэмцээнд оролцох тамирчид холбогдох бичиг баримтаа зааврын дагуу бүрдүүлж ирнэ.

6. Хувийн хэрэг
7. Иргэний үнэмлэх
8. Төрсний гэрчилгээ
9. ЭМД –ын дэвтэр
10. 2 % цээж зураг
11. Эрхийн төлбөр 5000 төгрөг
12. Тамирчдад тусгай номер олгоно

Холбоо барих утас: 99308228

Аймгийн БТС-ын Газар

БАТЛАВ  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

**ҮНДЭСНИЙ СПОРТЫН VI ИХ НААДМЫН АЙМГИЙН АВАРГА  
ШАЛГАРУУЛАХ ЖОРОО МОРИНЫ УРАЛДААНЫ ЗААВАР**

**Нэг. Зорилго**

Монгол улсын Засгийн газрын 2017 оны 269 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх, Монголын уламжлалт үндэсний спортын төрлүүд, уламжлалт тоглоом, зан үйл, ёс заншил, соёлыг өсвөр залуу үеийнхэнд өвлүүлэн сурталчилах, гадаадын жуулчид, судлаачдад сурталчлан таниулж хөгжүүлэхэд оршино.

**Хоёр. Наадам зохион байгуулах хугацаа**

Жороо морины уралдаан 2018 оны 07-р сарын 08-нд Төв аймгийн Батсүмбэр суманд зохион байгуулагдана.

**Гурав. Зааврын тодотгол**

Жороо морины уралдаан нь жороо явдалаа алдахгүйгээр хамгийн богино хугацаанд барианд орсныг түрүүлсэнд тооцох зарчмаар шалгаруулна. Уралдааны үед морийг зог тусгах, цогих, шогших зэргээр хөл алдуулж хэрхэвч болхгүй бөгөөд үүнийг алдаа гэж тооцон уралдааны хугацааг нэмэгдүүлнэ.

Энэхүү наадамд нэг сумаас хэдэн ч морь оролцохыг зөвшөөрнө. Уралдаанд оролцогч нь үндэсний хувцас хэрэглэлтэй байна.

**Наадамыг зохион байгуулах хороо**

БАТЛАВ.  
ТӨВ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР  
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА  
.....Га.ЛХАГВАСҮРЭН

БАТЛАВ.  
ТӨВ АЙМГИЙН ХӨЛБӨМБӨГИЙН  
ХОЛБООНЫ НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА.....С.УНДРАХБАТ

## ТӨВ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СПОРТЫН АНХДУГААР НААДМЫН ХӨЛБӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНИЙ ЗААВАР

### **Нэг. Тэмцээний зорилго**

- 1.1 Төв аймагт хөлбөмбөгийн спортыг сурталчилах, дэлгэрүүлэн хөгжүүлэхэд хувь нэмэр оруулах үүднээс “ТӨВ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ХӨЛБӨМБӨГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН”-ийг жил бүр, тогтмол зохион байгуулдаг болох
- 1.2 Аймгийн нийт төрийн албан хаагчдын хөлбөмбөг болон багийн спортыг сонирхож, хичээллэдэг болоход дэмжих, тэдний бие бялдар, оюун санааны хөгжилд сайн нөлөө үзүүлэх, тоглогчдын ур чадварыг сайжруулах
- 1.3 Аймаг, Сумдын шигшээ багуудыг хооронд нь өрсөлдүүлж, спортын шударга өрсөлдөөн бий болгохын зэрэгцээ аймаг, орон нутгийн иргэд, төрийн болон төрийн бус байгууллагууд эвлэлдэн нэгдэж, хөлбөмбөгийн баг тамирчдаа дэмждэг нөхөрсөг харилцааг бий болохыг дэмжих зорилготой.

### **Хоёр. Тэмцээний зохион байгуулалт, хугацаа**

- 2.1 “ТӨВ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ХӨЛБӨМБӨГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ АНХДУГААР ТЭМЦЭЭН-2018”-ийг Төв аймгийн Биеийн тамир Спортын Газар, Төв аймгийн Хөлбөмбөгийн Холбооноос томилсон Тэмцээн зохион байуулах комисс /ТЗБК/ удирдан явуулна.
- 2.2 Тэмцээнийг Монголын Хөлбөмбөгийн Холбооны “Тэмцээн зохион байгуулах журам”, “Сахилга бат ёс зүйн дүрэм”-ийн хүрээнд зохион байгуулна.
- 2.3 **Тэмцээн 2018 оны 6-р сарын 15-17 өдрүүдэд** Төв аймгийн БТС-ын Газрын Хөлбөмбөгийн талбайд зохион байгуулагдана.
- 2.4 Тэмцээн холимог системээр явагдах бөгөөд нийт оролцох багуудыг хэсэгт хувааж хэсгээс шалгарсан багуудыг хасагдах форматаар тоглуулж 2018 оны аварга багийг тодруулна.

### **Гурав. Тэмцээний дотоод журам болон баг тамирчдад тавих шаардлага**

- 3.1 Багийн гишүүд Төв аймгийн төрийн албан хаагч байна.
- 3.2 Багийн бүрэлдэхүүнд 11 тамирчин \2 хаалгач\, багийн менежер 1, дасгалжуулагч 1 хүн байна.
- 3.3 Тэмцээнд зөвхөн багийн мэдүүлэгт багтсан тоглогчид оролцоно.
- 3.4 Багийн мэдүүлэгт 0 дугаар буюу хувийн дугааргүй тоглогч мэдүүлэхгүй бөгөөд тоглогч тэмцээний туршид зөвхөн мэдүүлэгт бичигдсэн хувийн дугаар бүхий өмсгөлтэй байна.
- 3.5 Тэмцээнд оролцох багуудын эрхийн төлбөр 35.000 төгрөг.
- 3.6 Тэмцээний тоглолтыг шүүсэн талбайн шүүгчийн шийдвэр эцсийн шийдвэр байна.
- 3.7 Тэмцээнд оролцогч багууд өөрсдийн багийн нэр, бэлгэдэл бүхий 2 ээлжийн жигд өмсгөл, оймс, шилбэний хамгаалалт, зориулалтын пүүзтэй байна. Тоглолтын хувцас хувийн дугаартай байх бөгөөд мэдүүлэгт тамирчин бүрийн хувийн дугаарыг бичнэ.
- 3.8 Хаалгач талбайн тоглогчдоос өөр өнгийн зориулалтын тоглолтын хувцастай байна.
- 3.9 Багийн тамирчдын сахилга бат, ёс зүйн хариуцлагыг багийн ахлагч хариуцах ба ноцтой асуудал гаргасан тохиолдолд тэмцээнээс хасах хүртэл арга хэмжээ авна. Багийн нийт бүрэлдэхүүн, хөгжөөн дэмжигчдийг тэмцээний үеэр согтууруулах ундаа хэрэглэхийг хатуу хориглоно.
- 3.10 Тэмцээний тоглолтын хуваарь гармагц, баг тамирчид хувцас солих, бие халаалт хийхийн тулд тоглолтын хуваарьт цагаас 1 цагийн өмнө талбайд ирсэн байна.
- 3.11 Тоглолт хаяж явсан тохиолдолд тухайн багийн өмнөх тоглолтуудын оноог хүчингүй болгож 50.000 төгрөгөөр торгоно. Торгуулийн арга хэмжээг биелүүлэхгүй бол дараагийн тэмцээнүүдэд оролцуулахгүй.
- 3.12 Хэсгийн тоглолтын дүнг дараах байдлаар гаргана. Үүнд:
  - Хэсгийн тоглолтуудаас авсан хамгийн их оноогоор
  - Хэрэв 2 ба түүнээс дээш багууд ижил оноотой болсон тохиолдолд:



- Хоорондын тоглолтын дүнгээр
  - Хоорондын тоглолтын бөмбөгний зөрүүгээр
  - Хоорондын тоглолтын оруулсан гоолын ихээр
  - Хэсгийн бүх тоглолтод оруулсан гоолын зөрүүгээр
  - Хэсгийн бүх тоглолтод оруулсан гоолын ихээр
  - Багууд талбайд байвал торгуулийн цохилтоор
  - Шодолтоор
- 3.13 Тэмцээний нээлт болон хаалтын үйл ажиллагаанд багууд бүрэн бүрэлдэхүүнээрээ оролцох үүрэгтэй.
- 3.14 Тоглолт эхлэхэд багийн тоглогчийн тоо 6-аас доошгүй байж тоглолтыг эхлүүлэх боломжтой.
- 3.15 Тоглолт эхлэхийн өмнө өрсөлдөгч хоёр баг “FAIR PLAY” буюу ШУДАРГА ТОГЛОЛТ зарчмыг мөрдөж тоглохоо илэрхийлэн гар барих бөгөөд мөн тоглолт дуусахад уг тоглолтын үр дүнгээс үл хамааран хоёр багийн тоглогч нар өөр хоорондоо болон шүүгчидтэй гар барих үүрэгтэй.

#### **Дөрөв. Багуудийн бүртгэл**

“ТӨВ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ХӨЛБӨМБӨГИЙН АВАРГА ШАЛГАРУУЛАХ 2018 ОНЫ ТЭМЦЭЭН”-д оролцох багуудын сугалааг 2018 оны 6-р сарын 11-ний 10.00 цагт онлайнаар зохион байгуулах бөгөөд багийн мэдүүлгийг 2018 оны 6-р сарын 14-ны 14.00 цаг хүртэл хүлээн авна. Мэдүүлгийг хавсралт 1,2,3-ын дагуу загвар маягтаар бөглөж ирүүлнэ.

4.1 Дараах шаардлагуудыг хангаагүй мэдүүлгийг бүртгэж авахгүй.

- Зураг /сүүлийн 6 сард авахуулсан/ дутуу болон шаардлага хангаагүй.

- Мэдүүлэг баталгаат гарын үсэггүй.

- Хувийн дугааргүй

- Регистрийн дугааргүй

- Овог, нэр дутуу

4.2 Багууд тэмцээний мэдүүлгийг үнэн зөв бөглөж хариуцлагыг өөрсдөө хүлээнэ. Тэмцээний мэдүүлгийг санаатай хуурамчаар үйлдсэн тохиолдолд тухайн багийг тэмцээнээс хасч өмнөх тоглолтуудын оноог хүчингүйд тооцно.

4.3 Тэмцээний мэдүүлгийг БТСГ-ын бичиг хэргийн ажилтан Д.Энхцэцэгт ДУС-аар илгээнэ. Тэмцээнтэй холбоотой мэдээллийг БТСГ-ын дасгалжуулагч Ц.Батзаяа /89478428/ Төв аймгийн Хөлбөмбөгийн Холбооны нарийн бичгийн дарга С.Ундрахбат /88085980/ холбогдон авч болно.

#### **Тав. Техникийн зөвлөгөөн ба сугалаа**

5.1 Техникийн зөвлөгөөнд багийн дасгалжуулагч, ахлагч нар заавал оролцох шаардлагатай.

5.2 Техникийн зөвлөгөөнөөс хойш багийн мэдүүлэгт өөрчлөлт орохгүй ба мэдүүлэг хүлээн авах хугацаа дууссанаас хойш сугалаанд өөрчлөлт орохгүй.

#### **Зургаа. Тэмцээний төсөв, санхүүжилт**

5.1 Тэмцээнд оролцох зардлыг багууд бүрэн хариуцна.

5.2 Тэмцээн зохион байгуулах зардлыг Төв аймгийн БТСГ болон Төв аймгийн Хөлбөмбөгийн Холбоо хариуцна.

#### **Долоо. Шагнал урамшуулал**

6.1 Дараах шагналуудыг олгоно.

Нэгдүгээр байр: Алтан медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал

Хоёрдугаар байр: Мөнгөн медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал

Гуравдугаар байр: Хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагнал

6.2 Шилдэг хаалгач, Шилдэг тэгш тоглогч, мэргэн бууч нарыг Аймгийн хөл бөмбөгийн холбоо шалгаруулж урамшуулна.

**Найм. Бусад зүйл**

7.1 Тэмцээний үеэр дасгалжуулагч тамирчдын зүгээс FAIR PLAY зарчмыг хэрхэн хэрэгжүүлж байгаад хяналт тавина.

7.2 Зааварт тусгагдаагүй бусад асуудлыг ТЗБК-оос тухай бүр шийдвэрлэнэ.

БАТЛАВ  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН  
**ТӨВ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ХӨЛБӨМБӨГИЙН АВАРГА  
ШАЛГАРУУЛАХ 2018 ОНЫ ТЭМЦЭЭНД ОРОЛЦОХ БАГИЙН МЭДҮҮЛЭГ-1**

БАГИЙН НЭР	СОЁЛ СПОРТЫН БАГ	НАС, ХҮЙС		
	Овог Нэр Регистр Зэрэглэл	<b>Дасгалжуулагч</b> Т. БАТНАСАН НФ 85111419 НТБТ-ИЙН ДАРГА <b>Тоглогч</b>		<b>Багийн ахлагч</b> Овог Нэр Регистр Дугаар Эрүүл
	Овог Нэр Регистр Дугаар Эрүүл	ЦЭНД-ОЧИР БАТЗАЯА СК90042813 БТСГ-Т ДАСГАЛЖУУЛАГЧ		<b>Тоглогч</b> Овог Нэр Регистр Дугаар Эрүүл
	Овог Нэр Регистр Дугаар Эрүүл	<b>Тоглогч</b> Н ЭНХБАТ НЮ83042274 БСУГ-Т ЖИЖУҮР		<b>Тоглогч</b> Овог Нэр Регистр Дугаар Эрүүл
	Овог Нэр Регистр Дугаар Эрүүл	<b>Тоглогч</b> ХАТАНБААТАР БАТМӨНХ НЭ76102672 НОМЫН САНД ЖИЖУҮР		<b>Тоглогч</b> Овог Нэр Регистр Дугаар Эрүүл

**Тоглогч**  
Овог  
Нэр ДАШПҮРЭВ  
Регистр В388012211  
Дугаар  
Эрүүл МТТ-Т ДУУЧИН

**Тоглогч**  
Овог С  
Нэр НАРАНЦОГТ  
Регистр МЛ194040511  
Дугаар  
Эрүүл МТТ-Т  
БҮЖИГЧИН

**Тоглогч**  
Овог Ж  
Нэр САНДАГ-ОЧИР  
Регистр УП96051650  
Дугаар  
Эрүүл МТТ-Т  
БҮЖИГЧИН

**Тоглогч**  
Овог  
Нэр  
Регистр  
Дугаар  
Эрүүл

**Тоглогч**  
Овог  
Нэр  
Регистр  
Дугаар  
Эрүүл

**Тоглогч**  
Овог  
Нэр  
Регистр  
Дугаар  
Эрүүл


**ТӨВ АЙМГИЙН ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ХӨЛБӨМБӨГИЙН АВАРГА  
ШАЛГАРУУЛАХ 2018 ОНЫ ТЭМЦЭЭНДӨРӨЛЦӨХ БАГИЙН МЭДҮҮЛЭГ-3**

Багийн хувцасны өнгө:

Үндсэн өнгө (будаж тэмдэглэнэ үү)



Туслах өнгө (будаж тэмдэглэнэ үү)



Хаалгачийн хувцасны өнгө (будаж тэмдэглэнэ үү)



**ТЭМЦЭЭН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС**

## “ДУГУЙН АЯЛАЛ”-2018 АРГА ХЭМЖЭЭНИЙ УДИРДАМЖ

### 1.Зорилго

Нийтийн биеийн тамир спортын арга хэмжээний цар хүрээг өргөжүүлэх, бүх нийтийн оролцоог нэмэгдүүлэх, Дугуйн спортыг иргэдийн дунд сурталчлах, аялал зохион байгуулах.

### 2. Аялал, уралдаан явагдах газар хугацаа

2018 оны 6-р сарын 30 ны өдөр Аймгийн БТСГ,Цагдаагийн газар,Аймгийн нэгдсэн эмнэлэг ,TBS телевизхамтранзохионбайгуулна .Мөнх-Алдарын талбайгаас 10 цагт аялагчид нэгдсэн зохион байгуулалттай гарна.

### 3.Тамирчдын мэдүүлэг хүлээн авах

Аялалд 18-аас дээш насны иргэд оролцоно  
Албан байгууллага,аж ахуйн нэгж, багийн иргэд хэдэн ч хүн хамрагдаж болно.  
Аялалын бүртгэлийг 2018-06-28 ны өдрөөс эхлэн 06-30 ны 10,00 цаг хүртэл БТСГ-ын дугуйн дасгалжуулагч Г.Батсүх / 88404949/ дугаарт бүртгэнэ.

### 4.Аялалын үед зохиогдох арга хэмжээ

1.Туг сүлжихтэмцээн / баг бүрээс хэдэнч хүн оролцож болно/  
2.Багийнн буухиа уралдаан 4-н хүнтэй баг байна.  
/Тухайн үед багаа өөрсдөө сонгож оролцоно/  
3.Уулын этап / баг бүрээс хэдэнч хүн оролцож болно.  
Арга хэмжээнд оролцогчид каск ,бээлий, дугуйн бүрэн бүтэн байдлыг ханган аюулгүй байдлаа ханган оролцоно.  
Зохиогдох арга хэмжээнд давхардаж орохгүй.Нэг хүн нэг төрөлд орно.  
Амжилттай оролцогчдод 1-3 байр эзэлсэн оролцогчдод Мереди брэндийн дугуйн хэрэглэл материалаар шагнана.

### 5.Аялалд оролцогчдын аюулгүй байдал ба анхаарах зүйл

Оролцогчид тэмцээний цагаас хоцрохгүй байж аялалын дүрмийг баримтлаж ажиллах  
-Аялалын явцад замын байдлыг анхаарч дэг журамтай явах  
-Аялалд толгойн хамгаалалт ,бээлий, каск, тормоз бүрэн байх .  
-Аялалын эхэнд оролцогчидод аюулгүй ажиллагааны дүрэм танилцуулах гарын үсэг зуруулах ба дугуйн тормоз шалгана.  
Оролцогчид эрүүл мэндийн үзлэгт орсон байх.

БАТЛАВ  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

Дугуйн спортын тамирчин.....Төв аймаг БТСГазар  
тамирчинтай байгуулсан гэрээ

**Нэг.Зорилго.**

Төв аймгийн засаг даргын дэргэдэх өсвөр, залуучуудын шигшээ багийн дугуйн тамирчдыг дэмжих, дугуйн спортод авьяас чадвартай залуу тамирчдыг бэлтгэх, хөгжүүлэх залгамж халаа тамирчдыг бэлтгэх.

Улсын аварга шалгаруулах болон нэрэмжит тэмцээн уралдаанд амжилттай оролцох.

**Хоёр. Дасгалжуулагчийн хүлээх үүрэг.**

1. Тамирчдын нас бие, ур чадварт тохирсон сургалтын жилийн төлөвлөгөөтэй байх
2. Уралдаан тэмцээнд оруулах, амжилт, ур чадварыг нь ахиулах, амжилт үзүүлэх
3. Тамирчдын бэлтгэлжилт, амжилт, ур чадварын талаар судалгаа тооцоотой ажиллах.
4. Бэлтгэл, уралдааны үеийн хөдөлмөр хамгаалал, аваар осол аюулгүй байдлыг хангах
5. Тамирчдын сахилга, хүмүүжилд анхаарч зөв төлөвшүүлэх биенээ харилцан хүндтгэх.
6. Тамирчдад толгойн хамгаалалтын малгай өмсгөсөн байх.

ТӨВ АЙМГИЙН АХМАДЫН БАЙГУУЛЛАГЫН 30-Н ЖИЛИЙН ОЙН  
НЭРЭМЖИТ НИЙТИЙН ЦЭНГЭЭНТ БҮЖГИЙН АХМАДЫН “ШИЛДЭГ ХОС”  
ШАЛГАРУУЛАХ УРАЛДААНЫ УДИРДАМЖ

2018-06-06

Зуунмод

**Нэг. Уралдааны зорилго:**

Ахмад настангуудын чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, биеийн тамир, спортоор хичээллэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, нийтийн бүжгүүдийг сургах сурталчилах зорилготой.

**Хоёр. Оролцох журам:**

Аймгийн сум бүрээс 2 хос бүжигчид оролцоно. Зуунмод сумын баг бүрээс 1 хос бүжигчид оролцоно.

**Уралдаанд оролцох хосууд:**

1. Хүмүүн төрөлхтөн, задгай цагаан /холимогоор/
2. Вальс бостон буюу гурван тамирын уянга
3. Вальс бүжгээр бүжиглэж оролцоно

Уралдаанд оролцогч хосууд нь

- Эрэгтэй 55-аас дээш нас
- Эмэгтэй 50-наснаас дээш байх шаардлагатай

**Гурав. Шалгаруулах журам**

1. Хосуудын хувцаслалт
2. Ритм, хөгжим сонсолт
3. Орон зайн мэдрэмж
4. Уран чадвар, хосуудын харьцаа, соёл
5. Тухайн бүжгийн үндсэн манер зэргийг харгалзан мэргэжлийн шүүгчид шүүн явуулна.

**Дөрөв. Шагнал урамшуулал:**

Эхний 3-н байр эзэлсэн шилдэг хосуудыг алт, мөнгө, хүрэл медаль, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна. Шилдэгийн шилдэг 1 хосыг шалгаруулан “ГРАН ПРИ” шагнал олгож алтан медаль цом, өргөмжлөл, мөнгөн шагналаар шагнаж урамшуулна.

Мөн тусгай байр 2-ыг шалгаруулж шагнаж урамшуулна.

**Тав. Анхааруулга:**

Уралдаанд оролцох хосуудын мэдүүлгийг 2018 оны 06-р сарын 20-ний өдрийн 10<sup>00</sup> цагаас аймгийн Биеийн Тамир, Спортын Газарт авч мандат олгоно.

1. Сум орон нутгийн баталгаажуулсан мэдүүлэг байх
2. Эрхийн төлбөр 3000 төгрөг
3. Иргэний үнэмлэх
4. Хосууд нь аймаг болон сумдын үндсэн иргэд байх шаардлагатай

Бүжгийн уралдаан 2018 оны 06-р сарын 20-ны өдрийн 14<sup>00</sup> цагт Аймгийн БТС-ын Газрын Спорт зааланд болно

Холбоо барих утас 99781048, 86885350

Зохион байгуулах хороо

БАТЛАВ  
АЙМГИЙН БТС-ЫН ГАЗРЫН  
ДАРГА Га.ЛХАГВАСҮРЭН

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН СПОРТЫН АНХДУГААР НААДМЫН  
ТӨВИЙН БҮСИЙН ТЭМЦЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

2018.05.25

Зуунмод

Зохион байгуулагч: Зуунмод сумын ЗДТГазар  
Хамтран зохион байгуулагч: Аймгийн БТС-ын газар  
Аймгийн Волейболын холбоо  
Аймгийн Ширээний теннисний холбоо  
